

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



Э.БАЯРМАА

АНАТОМИЙН ЭМГЭГ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн буюу анагаах ухааны сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор нийтлүүлсэн өгүүлэл 3, өгүүлэл болон эрдэм шинжилгээний ажлын илтгэл хураангуй материал 3-аас доошгүйг хэвлүүлсэн байх;
2. Эмнэл зүй эмгэг судлалын конференци явуулах онолын болон практикийн мэдлэг, туршлагатай байж дүгнэлт гаргах чадвартай байх;
3. Мэс заслын эмгэг, дотор эрхтний дурангийн болон эмэгтэйчүүдийн амьд сорьцын болон хавдар болон хавдрын урталь эмгэгийн ялган оношилгоог хийх мэдлэг, чадвар, хандлагатай байх;
4. Эмгэг судлалын шинжилгээнд комисс ахалж орох, дүгнэлт гаргах, оношийг батлах мэдлэг, чадвар, хандлагатай байх;
5. Эмгэг судлалын оношлоход төвөгтэй тохиолдлыг гадаадын эх сурвалжаас олж мэдэх, оношлох, дүгнэх чадвартай байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн буюу анагаах ухааны сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор нийтлүүлсэн өгүүлэл 5, эрдэм шинжилгээний ажлын илтгэл хураангуй материал 5-аас доошгүйг хэвлүүлсэн байх;
2. Анатомийн эмгэг судлалын болон шинжээч эмчийн чиглэлээр ажиллаж буй залуу эмч, ахлах зэрэгтэй эмч нарт зөвлөгөө өгөх, үйл ажиллагааг үнэлэх, мэргэжил арга зүйгээр хангах чадвартай байх;
3. Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудаас санал болгосон шавилан сургалт, сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан тасралтгүй сургалтыг удирдан зохион байгуулсан байх;
4. Бүх төрлийн амьд сорьцыг олон улсын ангиллаар бие дааж үнэлгээ өгч, дүгнэх чадвартай байх;
5. Эмнэлзүй эмгэг судлалын конференцийн үйл ажиллагаанд үнэлгээ өгч, дүгнэх чадвартай байх;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

6. Төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх;
7. Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлсэн байх /гэрчилгээгээр баталгаажуулах/
8. Эмгэг судлалын оношлоход төвөгтэй болон ховор тохиолдлыг гадаадын эх сурвалжаас олж мэдэх, оношлох, дүгнэж, олон улсад хэвлэн нийтлүүлсэн байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш мэргэшлийн болон анагаах ухааны сэтгүүлд 8-аас доoshгүй өгүүллийг (нэгдүгээр болон хариуцлагатай зохиогчоор), эрдэм шинжилгээний ажлын илтгэлийн хураангуй материал 8 – аас доoshгүй нийтлүүлсэн байх;
2. Анатомийн эмгэг судлалын болон шинжээч эмчийн бүхий л үйл ажиллагаанд улсын хэмжээнд зөвлөх чадвартай байх;
3. 15-аас доoshгүй жил мэргэшлийн чиглэлээр төгсөлтийн өмнөх болон дараах сургалтад багшилсан байх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй залуу эмч, мэргэжилтнүүдийг шавилан сургах, зайн оношилгоо, онлайн зөвлөгөөг интернетээр өгдөг байх;
4. Орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд байгууллагын залуу эмч, мэргэжилтнүүдийг шавилан сургасан, байгууллагаас зохион байгуулсан сургалтад багшилсан байх/;
5. Амьд сорьцын бүхий л төрлүүдийг оношлох, зөвлөх чадвартай байх;
6. Эмгэг судлалын аль нэгэн төрөлжсөн салбараар түлхүү мэргэшсэн, зөвлөх түвшинд хүрсэн байх;
7. Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлсэн байх /гэрчилгээний хуулбар/;
8. Эмгэг судлалын оношлоход төвөгтэй болон ховор тохиолдлыг гадаадын эх сурвалжаас олж мэдэх, оношлох, дүгнэж, олон улсад хэвлэн нийтлүүлэх, хэлэлцүүлсэн байх.